



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

“Тэнгэр даатгал” ХХК-д дүрмийн сан
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолын 1.2 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Тэнгэр даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг тус компанийн 2011 оны хуримтлагдсан ашгаас нийт 500,000,000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:


	Хувь нийлүүлэгч	Дүрмийн сан /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь, %
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	“Петровис” ХХК	750,000,000.0	250,000,000.0	1,000,000,000.0	50%
2	“Тэнгэр санхүүгийн нэгдэл” ХХК	750,000,000.0	250,000,000.0	1,000,000,000.0	50%
	Нийт	1,500,000,000.0	500,000,000.0	2,000,000,000.0	100.0%

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг

001878

2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Тэнгэр даатгал” ХХК /Г.Цогбадрах/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

